



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/112/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Албан шаардлага	13
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.17 № 2/21

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.МАЙЖАРГАЛ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

• 005020234

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,517,136.00	27,671,180.00
33	АВЛАГА	80,011.00	483,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	80,011.00	483,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,437,125.00	27,188,180.00
354	Хангамжийн материал	30,437,125.00	27,188,180.00
35410	Бичиг хэргийн материал	3,755,696.00	5,615,622.00
35420	Аж ахуйн материал	24,750,758.00	17,964,278.00
35440	Түлш, шатах тослох материал	605,371.00	2,282,980.00
35470	Бусад хангамжийн материал	1,325,300.00	1,325,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	543,765,316.61	598,184,442.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	543,765,316.61	598,184,442.22
392	Биет хөрөнгө	480,225,566.74	534,913,442.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	488,335,355.19	492,054,510.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-76,863,206.65	-98,901,768.97
39203	Авто-гээврийн хэрэгсэл	78,936,000.00	140,936,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,436,000.00	-80,769,333.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,562,068.01	210,855,895.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,721,436.91	-157,699,952.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,106,235.12	98,106,235.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,453,648.02	-72,664,143.70
39214	Бусад үндсэн хөрөнгө	189,400.00	189,400.00
39217	Ном	2,570,800.00	2,806,600.00
393	Биет бус хөрөнгө	63,539,749.87	63,270,999.95
39301	Програм хангамж	1,891,000.00	1,891,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-872,250.13	-1,141,000.05
39303	Бусад биет бус хөрөнгө	62,521,000.00	62,521,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	574,282,452.61	625,855,622.22
413	Өглөг	80,011.00	483,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	80,011.00	483,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	574,202,441.61	625,372,622.22
51	Засгийн газрын хувь оролцоо	574,202,441.61	625,372,622.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	818,720,719.00	818,720,719.00
51101	Өмч: - төрийн	818,720,719.00	818,720,719.00
512	Хуримтлагдсан үр дүн	-283,130,468.15	-231,960,287.54
51210	Өмнөх үеийн үр дүн	-283,130,468.15	-283,130,468.15
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	51,170,180.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,612,190.76	38,612,190.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	574,282,452.61	625,855,622.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,048,860,320.00	1,115,882,615.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,085,420.00	82,389,815.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,085,420.00	82,389,815.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,085,420.00	82,389,815.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	20,157,740.00	81,917,127.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	927,680.00	472,688.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,027,774,900.00	1,033,492,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,014,274,900.00	1,033,492,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,274,900.00	1,033,492,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,500,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,058,536,175.78	1,064,712,434.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,058,536,175.78	1,064,712,434.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,005,027,490.78	1,050,309,118.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	759,374,430.00	786,330,590.00
210101	Үндсэн цалин	611,867,023.00	623,631,483.00
210102	Нэмэгдэл	99,031,949.00	113,030,317.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,336,000.00	25,424,177.00
210104	Урамшуулал	24,139,458.00	24,244,613.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,306,030.00	102,700,844.61
210201	Тэтгэврийн даатгал	66,319,580.00	71,334,844.61
210202	Тэтгэмжийн даатгал	7,855,313.00	8,082,923.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,609,905.00	6,268,464.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,440,667.00	1,548,342.07
210205	Эрүүл мэндийн даатгал	14,080,565.00	15,466,269.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,136,062.00	44,026,211.00
210301	Гэрэл, цахилгаан	4,555,650.00	4,366,986.00
210302	Түлш, халаалт	32,362,800.00	37,268,761.00
210303	Цэвэр, бохир ус	2,217,612.00	2,390,464.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,097,035.00	48,276,840.00
210401	Бичиг хэрэг	13,733,430.00	16,150,779.00
210402	Тээвэр, шатахуун	12,754,629.00	11,302,391.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,768,998.00	10,793,430.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	485,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,239,978.00	9,407,990.00
210408	Бараа материал ақталсны зардал	00.00	137,250.00
2105	Нормативт зардал	00.00	2,774,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,774,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,531,500.00	11,466,350.00
210601	Багаж, техник хэрэгсэл	216,600.00	4,440,336.00
210604	Урсгал засвар	5,314,900.00	7,026,014.00
2107	Томилолт, зочны зардал	5,078,000.00	7,211,900.00
210702	Дотоод албан томилолт	5,078,000.00	7,211,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,651,637.00	2,692,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,982,437.00	1,049,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,800.00	143,326.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	323,400.00	309,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,852,796.78	44,829,656.39
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,852,796.78	44,829,656.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,508,685.00	14,403,316.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,968,000.00	1,980,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,968,000.00	1,980,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,540,685.00	12,423,316.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,540,685.00	12,423,316.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-9,675,855.78	51,170,180.61
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-9,675,855.78	51,170,180.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/Төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,027,774,900.00	1,033,492,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,027,774,900.00	1,033,492,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,014,274,900.00	1,033,492,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,274,900.00	1,033,492,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,500,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,017,723,400.00	1,019,880,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,723,400.00	1,019,880,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964,214,715.00	1,005,476,983.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	759,374,430.00	786,330,590.00
210101	Үндсэн цалин	611,867,023.00	623,631,483.00
210102	Нэмэгдэл	99,031,949.00	113,030,317.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,336,000.00	25,424,177.00
210104	Урамшуулал	24,139,458.00	24,244,613.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,306,030.00	102,700,844.61
210201	Тэтгэврийн даатгал	66,319,580.00	71,334,844.61
210202	Тэтгэмжийн даатгал	7,855,313.00	8,082,923.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,609,905.00	6,268,464.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,440,667.00	1,548,342.07
210205	Эрүүл мэндийн даатгал	14,080,565.00	15,466,269.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,136,062.00	44,026,211.00
210301	Гэрэл, цахилгаан	4,555,650.00	4,366,986.00
210302	Түлш, халаалт	32,362,800.00	37,268,761.00
210303	Цэвэр, бохир ус	2,217,612.00	2,390,464.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,055,576.00	47,852,267.00
210401	Бичиг хэрэг	12,225,700.00	17,719,810.00
210402	Тээвэр, шатахуун	12,632,600.00	12,920,000.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	12,742,998.00	11,328,087.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	485,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,854,278.00	5,399,370.00
2105	Нормативт зардал	800,000.00	796,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	796,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,812,980.00	13,866,745.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	713,180.00	3,277,670.00
210604	Урсгал засвар	6,099,800.00	10,589,075.00
2107	Томилолт, зочны зардал	5,078,000.00	7,211,900.00
210702	Дотоод албан томилолт	5,078,000.00	7,211,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,651,637.00	2,692,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,982,437.00	1,049,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,800.00	143,326.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	323,400.00	309,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,508,685.00	14,403,316.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,968,000.00	1,980,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,968,000.00	1,980,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,540,685.00	12,423,316.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,540,685.00	12,423,316.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,051,500.00	13,612,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,051,500.00	13,612,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,051,500.00	13,612,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,051,500.00	13,612,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,051,500.00	13,612,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,051,500.00	-13,612,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-273,454,612.37	583,878,297.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-273,454,612.37	583,878,297.39
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-9,675,855.78	-9,675,855.78
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-283,130,468.15	574,202,441.61
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-283,130,468.15	574,202,441.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-283,130,468.15	574,202,441.61
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	51,170,180.61	51,170,180.61
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-231,960,287.54	625,372,622.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,033,492,800.00	1,021,069,483.61	12,423,316.39	98.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,033,492,800.00	1,021,069,483.61	12,423,316.39	98.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,492,800.00	1,019,089,483.61	12,403,316.39	98.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,757,600.00	786,330,590.00	427,010.00	99.95
210101	Үндсэн цалин	636,703,900.00	623,631,483.00	13,072,417.00	97.95
210102	Нэмэгдэл	107,118,300.00	113,030,317.00	-5,912,017.00	105.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,938,200.00	25,424,177.00	2,514,023.00	91.00
210104	Урамшуулал	14,997,200.00	24,244,613.00	-9,247,413.00	161.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,552,500.00	102,700,844.61	3,851,655.39	96.39
210201	Тэтгэврийн даатгал	74,947,700.00	71,334,844.61	3,612,855.39	95.18
210202	Тэтгэмжийн даатгал	7,901,200.00	8,082,923.92	-181,723.92	102.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,321,000.00	6,268,464.51	52,535.49	99.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,580,200.00	1,548,342.07	31,857.93	97.98
210205	Эрүүл мэндийн даатгал	15,802,400.00	15,466,269.50	336,130.50	97.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,027,100.00	44,026,211.00	889.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,367,400.00	4,366,986.00	414.00	99.99
210302	Түлш, халаалт	37,268,800.00	37,268,761.00	39.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,390,900.00	2,390,464.00	436.00	99.98
2104	Хангамж, бараа материалын зардал	51,644,000.00	47,852,267.00	3,791,733.00	92.66
210401	Бичиг хэрэг	18,929,000.00	17,719,810.00	1,209,190.00	93.61
210402	Тээвэр, шатахуун	14,682,000.00	12,920,000.00	1,762,000.00	88.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,943,000.00	11,328,087.00	614,913.00	94.85
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэргэчдийн устгал, ариутгал	690,000.00	485,000.00	205,000.00	70.29
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,400,000.00	5,399,370.00	630.00	99.99
2105	Нормативт зардал	800,000.00	796,000.00	4,000.00	99.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	796,000.00	4,000.00	99.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,580,000.00	27,479,245.00	100,755.00	99.63
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,580,000.00	16,530,170.00	49,830.00	99.70
210604	Урсгал засвар	11,000,000.00	10,949,075.00	50,925.00	99.54
2107	Томилголт, зочны зардал	9,984,300.00	7,211,900.00	2,772,400.00	72.23
210702	Дотоод албан томилолт	9,984,300.00	7,211,900.00	2,772,400.00	72.23
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,147,300.00	2,692,426.00	1,454,874.00	64.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,177,900.00	1,049,000.00	1,128,900.00	48.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	847,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,900.00	143,326.00	18,574.00	88.53
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	0.00	247,500.00	0.00
210807	Газрын төлбөр	369,000.00	309,100.00	59,900.00	83.77

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000000.00	1980000.00	20,000.00	99.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,980,000.00	20,000.00	99.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,980,000.00	20,000.00	99.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,033,492,800.00	1,021,069,483.61	12,423,316.39	98.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,033,492,800.00	1,021,069,483.61	12,423,316.39	98.80
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,033,492,800.00	1,021,069,483.61	12,423,316.39	98.80
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	38.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	05.00	05.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	00.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00	00.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.00	16.00	00.00	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12.00	12.00	00.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	00.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг дарга М.Майжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхзул нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийн байгууллага нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлж, хамгаалах, Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, Хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, Шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах
- Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах үйл ажиллагааг тасралтгүй явуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,058,536.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,878.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,114.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,170.2 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,517.1	27,671.2	(2,846.0)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	80.0	483.0	403.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	30,437.1	27,188.2	(3,248.9)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	543,765.3	598,184.4	54,419.1
Үндсэн хөрөнгө	910,111.9	1,009,360.6	99,248.8
Хуримтлагдсан элэгдэл	(366,346.5)	(411,176.2)	(44,829.7)
Нийт хөрөнгө	574,282.5	625,855.6	51,573.2
Өр төлбөр	80.0	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	574,202.4	625,372.6	51,170.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	574,282.5	625,372.6	51,170.2

Авлагын дансны үлдэгдэл 403.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх онд ажиллагсадтай холбоотой 80.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын татварын авлага үүссэнийг тайлант онд барагдуулсан, ажиллагсадтай холбоотой 483.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27,188.2 мянган төгрөг болж 3,248.9 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, аж ахуйн материалын дансанд үлдэгдлээр тайлагнасан 11,781.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,009,360.6 мянган төгрөг болж 99,248.8 мянган төгрөгөөр өссөн нь 13,612.5 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 95,529.6 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн орлого авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 625,372.6 мянган төгрөг болж 51,170.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 51,170.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,057,900.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,057,900.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 38,370.9 мянган төгрөгөөр бууруулж 1,019,529.7 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг улсын төсвийн 1,033,492.8 мянган төгрөгийн санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,033,492.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,021,069.5 мянган төгрөгийг зарцуулж 12,423.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,021,069.5 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 4,278.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 3,791.8 мянга, албан томилолтын зардлыг 2,772.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,454.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тусгай чиг үүргийн байгууллага бөгөөд тайлант онд тээвэр шатахууны төсвөөс хэмнэгдсэн зардлыг оны эцэст төвлөрүүлэлгүй шүүн таслах үйл ажиллагааг тасралтгүй явуулах чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд 2282.9 мянган төгрөгийн шатахууны талон худалдан авч материалын үлдэгдлээр тайлагнасан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 85.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,115,882.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 6,176.2 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,054,630.9 мянган төгрөгийн 27 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, худалдан авалттай холбоотой 30217.9 мянган төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд урсгал төсвийн зарцуулалт нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,164.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,795.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,719.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,933.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,076.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 66.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд байгууллагын гадна хашааны засварын ажилд 3,719.2 мянган төгрөгийг зарцуулсан ч үндсэн хөрөнгөд бүртгээгүй урсгал зардлаар бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.34 дахь “Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дансанд залруулав.

4.2 Төлбөрийн акт

Тус байгууллага нь 6, 7 дугаар саруудад 1933.5 мянган төгрөгийн цалинг 2 албан хаагчид илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

1. Ажиллагсдын цалинг 2021 оны 05, 06, 07, 10 дугаар саруудад Нийгмийн даатгалын хэлтэст 2,076.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 2,076.6 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага нь 2021 онд нийт 1,054,630.9 мянган төгрөгийн 27 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, худалдан авалттай холбоотой 30217.9 мянган төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Тус байгууллагын программ хангамжийн дансанд 1,891.0 мянган төгрөгийн программ хангамж бүртгэлтэйгээс 66.0 мянган төгрөгийн программын сунгалтын төлбөрийг бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.29 дахь “Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ыг дагаж мөрдөнө” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Толилуулга”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх программын сунгалтын төлбөрийг хөрөнгөд бүртгэсэн асуудлыг холбогдох газарт асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс	5	7795.3	1	3719.2	1	1933.5	2	2076.6	1	66.0

_____оОо_____